

**МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2014  
ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХОЁР ДАХЬ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 12 дугаар  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа**

Төсвийн Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд зэ,

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2014 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа эдгээр хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Төслийн талаар тус байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Ж.Эрдэнэбат танилцуулга хийж, Улсын Их хурлын гишүүн А.Тлейхан, Ё.Отгонбаяр, Л.Энх-Амгалан, Г.Баярсайхан, Д.Батцогт нарын асуултад холбогдох сайдууд хариулт өглөө.

Хуралдааны үеэр зарчмын зөрүүтэй санал гаргаагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүд сүүлийн 3 жилд орлого нь тасарсан төсвийн төсөл өргөн барьдаг хариуцлагагүй тогтолцоо зурсил болж буйг тэмдэглэн цаашид төсвийг эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дээр тулгуурлан эрүүл, бодитой болгох шаардлагатайг анхааруулав.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд зэ,

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж Төслийн байнгын хороонд хүргүүлэхийг тус байнгын хорооны гишүүд дэмжсэнийг үүгээр уламжлав.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.БАТЦОГТ

